



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**



Сүхбаатар сум

ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл.....	3
АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР	4
1. ХҮН АМ, НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ	14
1.1 Хүн ам.....	14
1.2 ЭРҮҮЛ МЭНД	15
1.3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	21
1.4 НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ.....	23
1.5 ГЭМТ ХЭРЭГ.....	24
2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	26
2.1 МӨНГӨ, ЗЭЭЛ	26
2.2 АЙМГИЙН НЭГДСЭН ТӨСӨВ, ТАТВАР	28
2.3 ГАДААД ХУДАЛДАА	30
2.4 ҮНЭ	30
3. ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ	33
3.1 ХӨДӨӨ АЖ АХУЙ	33
3.2 АЖ ҮЙЛДВЭР	39
4. БУСАД.....	37



Ерөнхий тэмдэглэл

- I. Товчилсон тэмдэглэлгээ:
- ГХ- Гэмт хэрэг
 - Х.н-Хэмжих нэгж
 - ХАА- Хөдөө аж ахуй
 - АҮ - Аж үйлдвэр
 - ЖДҮ- Жижиг дунд үйлдвэрлэл
 - СЭ - Сэлэнгэ
 - НХ – Нийгмийн халамж
 - ХЧТА-Хөдөлмөрийн чадвараа түр алдсан
 - ЖА-Жирэмсний амралт
 - ҮОМШӨ-Үйлдэрийн осол мэргэжлээс шалгаалах өвчин
 - НӨАТ-Нэмэгдсэн өртгийн албан татвар
 - ҮХЭХӨЭ- Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх
 - ГӨЭ-Газар өмчлөх эрх
 - ШША-Шүүхийн шинжилгээний алба
 - ШШГГ-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
 - НДШ-Нийгмийн даатгалын шимтгэл
- II. Саруудыг ромбо тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)
- III. Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XI зэргээр илэрхийлэв
- IV. Дараах тэмдэглэлийг ашиглав:
- ... Мэдээлэл байхгүй
 - Х Бүтцийн өөрчлөлт
 - 0.0 Маш бага тоо
 - +, - Зөрүү
 - Гүйцэтгэл байхгүй
 - * Дахин
- "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.
- V. "Төл" нь төлөвлөгөө, "Гүйц" нь гүйцэтгэл
- VI. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100.0 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

Төсөв: Аймгийн төсвийн орлого зарлага нь төвлөрсөн төсвийн болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

Ажилгүйчүүд: Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орно.

Бүртгэлтэй ажилгүй иргэд: Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Нийгмийн даатгал: нь иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчид тооцно.

Үнэ: Аймгийн төвийн захад борлогдож байгаа болон хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийг харуулна.

Хэрэглээний үнийн индекс: Өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.



Гэмт хэрэг: Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүй алах хэргийг, хүүхэд гэр бүл нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулав.

Хээлтэгч мал: Нас гүйцсэн эм малыг хамруулна.

Зүй бусаар хорогдсон малын тоонд: Халдвартай , халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга, цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, худаг, хавцалд унах зэрэг хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

Аж үйлдвэр: Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хэмжээ юм. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцоход нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2016 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.



Сэлэнгэ аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

(2020 оны эхний 4 сарын байдлаар)

1. НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ



1.1 Хүн ам

2020 оны эхний 4 сарын байдлаар манай аймагт бусад аймаг хотоос бүгд 402 хүн шилжин ирсэн нь өмнөх оны мөн үеэс 736 (83.1%) хүнээр буурсан үзүүлэлттэй байна. Нийт шилжин ирэгсдийн 207 (51.5%) нь эрэгтэйчүүд, 195 (48.5%) нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэйчүүдийн тоо 364 (36.2%) хүнээр, эмэгтэйчүүдийн тоо 372 (51.6%) хүнээр тус тус буурсан байна.

2020 оны Их хурлын сонгуультай холбоотойгоор шилжилт хөдөлгөөнийг 02 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн зогсоосон тул 1 сарын мэдээллээр авсан болно.




1.2 Эрүүл мэнд

2020 оны 4 дүгээр сарын байдлаар аймгийн хэмжээгээр нийт 550 эх амаржиж, 555 хүүхэд төрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс амаржсан эх, амьд төрсөн хүүхэд тус тус 60-аар буурсан байна. Төрөлтийг насны бүтцээр нь харахад 25-29 насны 148 (26.9%), 20-24 насны 130 (23.6%), 30-34 насны 144 (26.2%), 35-39 насны 82 (14.9%), 40-44 насны 20 (3.7%), 20 хүртэлх насны 26 (4.7%)-ийг тус тус эзэлж байна.

Нас барсан хүний тоо 169 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 6 (3.7%)-аар нэмэгдсэн байна. Нийт нас баралтын шалтгааны 10.7 хувь нь осол гэмтлийн, 33.7 хувь нь хорт хавдрын өвчний шалтгаантай байна. 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 2 тохиолдол тус тус бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 20.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Төрсөн эх, амьд төрсөн хүүхэд



Халдварт өвчнөөр 367 хүн өвчилж бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 128 (53.6%)-аар нэмэгдсэн байна. Нийт халдварт өвчний 86.1 хувийг бэлгийн замын халдварт өвчин, 9.8 хувийг сүрьеэ, 4.1 хувийг бусад халдварт өвчин эзэлж байна.

2020 оны 4 дүгээр сард нийт 129 972 үзлэг хийсний 21.5 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 22.5 хувь нь гэрийн идэвхитэй үзлэг, 31.0 хувь нь диспансерийн хяналтын үзлэг эзэлж, нийт 11 579 дуудлаганд үйлчилсний 12.9 хувийг алсын дуудлагаар үйлчилж яаралтай тусламж үзүүлсэн.




1.3 Хөдөлмөр

2020 оны 4 дүгээр сарын байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 579 болсон нь өмнөх оны мөн үеэс 181 (23.8%) хүнээр буурч, өмнөх сараас 34 (6.2%) хүнээр өссөн байна. Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 579 болсны 261 (45.1%) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 55.4 хувийг ерөнхий боловсролтой, 24.2 хувийг дээд боловсролтой, 14.2 хувийг мэргэжилтэй ажилчид, 5.7 хувийг тусгай дунд боловсролтой, 0.5 хувийг боловсролгүй хүмүүс эзлэх боллоо. Шинэ ажлын байранд 144 иргэн ажилд зуучлагдсаны 36 иргэн боловсролын салбарт, 9 иргэн тээвэр, холбооны салбарт, 36 иргэн ХАА, Ойн аж ахуй, загас ан агнуурын салбарт, 16 иргэн уул уурхай, олборлох үйлдвэрт, 12 иргэн боловсруулах үйлдвэрт, 35 бусад салбарт ажилд орсон байна.

Энэ сард бүртгэлтэй ажилгүйчүүдээс 43 хүн ажилд зуучлагдан орж, 86 хүн идэвхгүйн улмаас хасагдаж, 163 хүн шинээр бүртгэгдсэн байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролоор




1.4 Нийгмийн даатгал, халамж

2020 оны 4 дүгээр сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 17 328 тэтгэвэр авагчдад 26 214.8 сая төгрөгийг олгосон нь өмнөх оны мөн үеэс тэтгэвэр авагчид 640 (3.8%) хүнээр өсч, олгосон тэтгэврийн хэмжээ 3 252.3 (14.2%) сая төгрөгөөр өссөн байна. Тэтгэмжийн даатгалын сангаас 2 184 хүнд 1 134.2 сая төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин, даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 218 хүнд 386.2 мянган төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангаас 152 хүнд 409.3 мянган төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгожээ.

Нийгмийн халамжийн сангаас 33 961 хүнд 5 666.1 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг олгосон нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 139 (0.4%) хүнээр буурч, олгосон тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ 315.7 (5.9%) сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн даатгалын орлого, сая. төг






1.5 Гэмт хэрэг

2020 оны эхний 4 сарын байдлаар нийт 226 гэмт хэрэг бүртгэгдсэн өмнөх оны мөн үеэс 56 (19.9%) хувиар буурсан байна. Нийт гэмт хэргийн 41 (18.1%) нь согтуугаар үйлдэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 22 (34.9%)-оор буурчээ.

Иргэн болон байгууллагад нийт 475.7 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеэс 308.7 (1.6 дахин) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлоос 117.5 сая төгрөгийг нөхөн төлүүлж, нөхөн төлөлт 24.7 хувьтай байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 92 (40.7%) нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 81 (35.8%) нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 24 (10.6%) нь байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, 6 (2.7%) нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 23 (10.2%) нь бусад төрлийн гэмт хэрэг эзэлж байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 26 (28.2%) нь малын хулгай байгаа нь өмнөх оны мөн үеэс 9 (25.7%)-өөр буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр, хувиар




1.6 Хилээр орсон, гарсан иргэд

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг болон Сүхбаатар боомтоор давхардсан тоогоор 94.4 мянган зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 110.5 (53.9%) мянган хүнээр буурсан байна. Нийт зорчигчдын 73.6 (78.0%) мянга нь Монгол иргэд, 20.8 (22.0%) мянга нь гадаад иргэд байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хилээр нэвтэрсэн Монгол иргэдийн тоо 97.1 (56.9%) мянган хүнээр, гадаад иргэдийн тоо 13.4 (39.2%) мянган хүнээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.


Монгол-Оросын хилийг хялбарчилсан журмаар хил нэвтрэх эрхийн үнэмлэхээр 5 197 хүн зорчсон байна.

Хилээр орсон, гарсан иргэд



**2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ****2.1 Мөнгө, банк**

Монгол банкны мэдээгээр зээлийн өрийн үлдэгдэл 269 082.9 сая төгрөг байгаа ба үүний 3.3 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Нийт харилцахын үлдэгдэл 38 776.4 сая төгрөг, иргэдийн мөнгөн хадгаламж 110 916.8 сая төгрөг байна. Аймгийн хэмжээнд банкны нийт 64 салбар нэгжид 376 ажилтан ажиллаж байна.

Зээлийн өрийн үлдэгдэл /тэрбум.төг/**2.2 Төрийн сан, татвар**

2020 оны 4 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 6 986.2 сая (81.7%) төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс аймгийн төсвийн орлого 5 294.3 сая (79.6%) төгрөгийн гүйцэтгэлтэй, сумдын төсвийн орлого 1 692.0 сая (88.8%) төгрөгийн гүйцэтгэлтэй байна. 2020 оны 4 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн зарлага 26 798.9 сая (70.7%) төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлага 8 224.7 сая (57.3%), Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлага 18 574.1 сая (78.9%) төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Сумдад 5 271.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 17 905.0 сая төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг, 636.3 сая төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг тус тус шилжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гүйцэтгэл 220.0 сая (98.9%) төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна.


Орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, /сая.төг/



2.3 Гадаад худалдаа

Сэлэнгэ аймагт 2020 оны эхний 4 сарын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлт 81.3 сая америк доллар, үүнээс экспорт 0.9 сая америк доллар, импорт 80.3 сая америк доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.4 (2.8%) сая америк доллараар, экспорт 0.8 (44.8%) сая америк доллараар, импорт 1.6 (1.9%) сая америк доллараар өссөн байна.

Гадаад худалдааны бараа эргэлт, сая.\$




2.4 Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 4 сард өмнөх сараас 0.5 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар өсөхөд боловсролын үйлчилгээ 11.5 хувь, хүнсний бараа согтууруулах бус ундаа 5.1 хувь, согтууруулах ундаа тамхи мансууруулах бодис 5.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш 3.1 хувь, гэр ахуйн тавилга гэр ахуйн бараа 2.8 хувь, хувцас, бөс бараа, гутал 2.2 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ 0.2 хувиар тус тус өсч, тээврийн бүлэг 4.0 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.5 хувиар буурахад тээврийн бүлэг 6.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш 0.8 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны мөн үе), хувь



ХАА-н бүтээгдэхүүний үнэ.

2019 оны мөн үеэс малын үнэ 20 000 - 300 000 төгрөгөөр буурсан байна. Түүхий эдийн хувьд адууны дэл, сүүл 1 000 төгрөг, ямааны ноолуур 50 000 төгрөгөөр тус тус худалдаалагдаж байна.



3.ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ



3.1 Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд 2019 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 788.8 мянган хээлтэгч малын 548.5 мянга (69.5%) нь 2020 оны эхний 4 сарын байдлаар төллөсөн байна. Эм хонины 75.5 хувь, эм ямааны 75.7 хувь, ингэний 38.5 хувь, үнээний 42.7 хувь, гүүний 32.8 хувь нь төллөжээ.

Том малын зүй бус хорогдол 2020 оны эхний 4 сарын байдлаар аймгийн хэмжээнд 2 112 толгой болж, өмнөх оны мөн үеэс 362 (20.7%) толгойгоор өслөө. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, хонь 865 толгой, ямаа 647 толгой, үхэр 363 толгой, адуу 235 толгой, тэмээ 2 толгойгоор тус тус хорогдсон байна. Нийт хорогдсон малын 41.0 хувийг хонь, 30.6 хувийг ямаа, 17.2 хувийг үхэр, 11.1 хувийг адуу, 0.1 хувийг тэмээ тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд эхний 4 сарын байдлаар 300 га-д үр тариа, 49.7 га-д төмс, 108.5 га-д хүнсний ногоо тариалсан байна.




3.2 Аж үйлдвэр

2020 оны эхний 4 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 118.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 166.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь урьд оны мөн үеэс үйлдвэрлэлт 12.9 (12.2%) тэрбум төгрөгөөр, борлуулалт 20.2 (13.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 71.3 (60.1%) тэрбум төгрөг нь уул уурхайн салбарт, 42.3 (35.6%) тэрбум төгрөг нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 5.1 (4.3%) тэрбум төгрөг нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт бүтээгдсэн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт (тэрбум төг)





4. БАЙГАЛЬ ОРЧНЫ СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ



4.2 Цаг уур орчны мэдээ

ТАНЫ АНХААРАЛД

Цаг агаарын сарын урьдчилсан мэдээнд тухайн сард агаарын дундаж температур, орох хур тунадасны хэмжээ нь олон жилийн дундажтай харьцуулахад ямар байхыг баруун (Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай, Баянхонгор), төв (Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв, Орхон, Дархан-Уул), зүүн (Хэнтий, Дорнод, Сүхбаатар), говийн (Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говь-Сүмбэр) нутгийн гэсэн 4 бүс нутаг тус бүрээр ялган зааж өгдөг. Түүнчлэн тухайн сарын хэдий үед нутгийн аль хэсэгт дулаарах, хүйтрэх, бороо, цас орох, салхи шуурга болохыг тусгана. Цаг агаарын үзэгдэл нутгийн 30 хувиас хэтрэхгүйгээр зурвас газраар ажиглагдах тохиолдолд "зарим газраар", 30-70 хувьд "ихэнх нутгаар", 70 хувиас дээш нутгийг хамрах тохиолдолд "бүх нутгаар" гэсэн нэр томъёо хэрэглэдэг. Дулааны улиралд агаарт болон хөрсний гадарга дээр температур 0⁰-аас бага болж хүйтрэхийг "цочир хүйтрэл" гэнэ.

Цаг агаарын урьдчилсан мэдээг өдөр бүр 12 цагаар болон нэг, тав хоногоор нарийвчлан гаргаж радио, телевиз, хэвлэлээр нийтэд мэдээлдэг. Цаг агаарын байдал эрс өөрчлөгдөн цаашид хөдөө аж ахуйн болон эдийн засгийн бусад салбарын хэвийн үйл ажиллагаанд саад учруулахаар аюултай үзэгдлийн хэмжээнд хүрч болзошгүй тохиолдолд "Урьдчилан анхааруулах мэдээ", "Урьдчилан сэрэмжлүүлэх мэдээ" гаргаж радио, телевизээр нийт ард иргэдэд, харин эд хөрөнгө, иргэдийн амь нас хохирохоор онц аюултай үзэгдлийн хэмжээнд хүрэхээр бол "Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ" гаргаж "Харанга" дохиотойгоор мэдээлэх ба мэдээллийг онцгой байдлын шугамаар нийт ард иргэд, төр засгийн бүх шатны удирдлагад шуурхай хүргэдэг. Холбогдох газрын удирдлага "Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ"-г хүлээн авмагц мэдээллийг өөрийн харъя нутаг дэвсгэрийн иргэдэд хүргэх, гамшгаас хамгаалах, гамшгийн голомтод ажиллах, сэргээн босгох үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах үүрэгтэй.

Ус, цаг агаарын гамшигт үзэгдлийн улмаас хүний амь нас эрстсэн, байгаль орчин, эд хөрөнгөнд хохирол учирсан тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга ажлын хэсэг томилон ажиллуулж, уг гамшигт үзэгдлээс хамгаалах талаар зохион байгуулсан арга хэмжээ, үр дүн, учирсан хохирол, гарсан зардлын талаарх мэдээллийг нэгтгэн аймаг, нийслэлийн Засаг дарга, Онцгой байдлын газар, хэлтэс, Улсын онцгой байдлын ерөнхий газар, аймгийн Цаг уур, орчны шинжилгээний алба, Улаанбаатар хотын Ус цаг уурын хүрээлэнд 3 хоногийн дотор ирүүлнэ.

Цаг агаарын мэдээний талаар лавлах, эсвэл байгаль цаг уурын сонин хачин үзэгдлийн талаарх мэдээллийг Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн 326606, 326609 утсаар өгөх юмуу "УБ-46, Жуулчны гудамж-5, Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн "Орчил урсгал, урт хугацааны прогнозын судалгааны хэлтэс" гэсэн хаягаар ирүүлнэ.



Уур амьсгалын тойм *Climate review*

Тавдугаар сарын агаарын температурын ОЖД нь бүх сумдын нутгаар нутгаар 11-14 градус дулаан байдаг.

Тавдугаар сард агаарын дундаж температур сүүлийн жилүүдэд, ялангуяа 2017-2018 онуудад хамгийн дулаан буюу ОЖД – аас 2⁰С-аар дулаарч өдөртөө 31-36⁰С хүрч халж байв. Харин 2014-2016, 2019 онуудад ОЖД – аас 0.5-1.0⁰С-аар хүйтэн байсан байна.

Тав дугаар сард ОЖД – аар бүх сумдын нутгаар 11-25 мм хур тунадас ордог.

Зарим жил ОЖД – аас хэд дахин их болон бага хур тунадас орох тохиолдол цөөнгүй байдаг. Тухайлбал, 1979-1986, 1994, 1996, 1998, 2017, 2018, 2019 онуудад ихэнх сумдын нутгаар дунджаас харьцангуй бага хур тунадас орж хуурайшилт ихтэй байсан бол 1988, 2002, 2003, 2014, 2016 онуудад ихэнх сумдын нутгаар олон жилийн дунджаас ахиу хур тунадас орсон байна.

Тавдугаар сард салхины хурд 15 м/с-ээс дээш ширүүсч шороон шуурга шуурах тохиолдол олон жилийн дунджаар 5-7 удаа ажиглагддаг шороон болон цасан шуурга шуурдаг.

5. БУСАД

А. Хяналт шалгалт

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2020 оны эхний 4 сарын байдлаар 90 аж ахуйн нэгж байгууллага, 60 иргэнд шалгалт хийж, 1142 зөрчил дутагдал илрүүлж, 212 зөрчил арилгуулсан байна.

Б. Онцгой байдлын газрын мэдээ

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 119 объект, 117 айл өрхөд үзлэг шалгалт хийж 376 зөрчил илрүүлэн 61 зөрчил дутагдлыг арилгуулсан байна. 2019 оны эхний 4 сарын байдлаар объектод 62, ой хээрийн 6 гал түймэр гарч 4 371.6 сая төгрөгийн хохирол учирсан байна.

В. Түүвэр судалгаа


2020 оны 4 дүгээр сарын байдлаар Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг 208 өрхөөс, Ажиллах хүчний судалгааг 220 өрхөөс авч, судалгаанд хамрагдсан өрхүүдэд урамшуулал болгон 2 764.0 мянган төгрөг олгоод байна.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Д.ГҮНДЭГМАА

**1. ХҮН АМ, НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ****1.1 Хүн ам****1.1.1 ШИЛЖИЖ ИРСЭН ИРГЭДИЙН ТОО, сумаар**

Сумын нэр	2016 I-IV	2017 I-IV	2018 I-IV		2019 I-IV		2020 I-IV	
			Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Дүн	863	774	971	512	1 138	567	402	195
Алтанбулаг	30	37	16	8	16	8	5	4
Ерөө	41	60	48	28	59	24	33	18
Зүүнбүрэн	26	26	29	20	28	13	10	5
Мандал	150	157	380	219	390	192	93	49
Орхон	17	14	12	3	14	7	5	1
Сант	17	17	32	15	38	16	14	4
Цагааннуур	38	21	16	7	50	27	18	10
Баянгол	48	59	55	25	68	34	25	12
Сайхан	115	71	55	20	159	74	49	22
Орхонтуул	26	35	24	16	45	24	26	14
Баруунбүрэн	23	21	26	14	46	26	24	13
Шаамар	21	47	31	19	44	25	14	7
Хүдэр	24	16	20	7	31	14	11	5
Сүхбаатар	202	151	179	91	86	53	39	17
Жавхлант	31	16	12	5	23	11	11	5
Түшиг	29	5	12	4	26	14	7	3
Хушаат	25	21	24	11	15	5	18	6

Эх үүсвэр: Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

Шилжиж ирсэн иргэдийн тоо

**1.2 ЭРҮҮЛ МЭНД****1.2.1 ТӨРӨЛТ**

Сумын нэр	Төрсөн эх				<u>2020 I-IV</u> <u>2019 I-IV</u>
	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV	
ДҮН	518	552	610	550	90.2
Алтанбулаг	1	1			
Ерөө	5	16	14	17	121.4
Зүүнбүрэн	1	3	1	1	100.0
Мандал	184	193	200	221	110.5
Орхон					
Сант				1	
Цагааннуур	6	7	4	3	75.0
Баянгол	3	1	1		
Сайхан	28	22	30	34	113.3
Орхонтуул	1	4			
Баруунбүрэн		2	1	1	100.0
Шаамар	1	2			
Хүдэр	1	1	1	1	100.0
Сүхбаатар	284	294	350	271	77.4
Жавхлант	1				
Түшиг	2	5	8		
Хушаат		1			

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

1.2.2 АМЬД ТӨРСӨН ХҮҮХДИЙН ТОО

Сумын нэр	Амьд төрсөн хүүхэд								<u>2020 I-IV</u> <u>2019 I-IV</u>
	2017 I-IV		2018 I-IV		2019 I-IV		2020 I-IV		
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	
Бүгд	518	310	553	261	615	299	555	275	90.2
Алтанбулаг	1	1	1						
Ерөө	5	4	17	10	15	6	17	9	113.3
Зүүнбүрэн	1	1	2		1		1	1	100.0
Мандал	185	113	193	96	203	100	222	122	109.4
Орхон									
Сант							1		
Цагааннуур	5	3	7	4	4	2	2	1	50.0
Баянгол	2	2	1		1				
Сайхан	28	20	22	12	31	17	34	13	109.7
Орхонтуул	1	1	4						
Баруунбүрэн			2	2	1		1		100.0
Шаамар	1		2	1					
Хүдэр	1	1	1		1		1	1	100.0
Сүхбаатар	285	163	294	132	350	169	276	128	78.9
Жавхлант	1	1							
Түшиг	2		6	4	8	5			
Хушаат			1						

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.3 ТӨРСӨН ЭХ, боловсролоор**

Үзүүлэлт	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV	<u>2020 I-IV</u> <u>2019 I-IV</u>
Бүгд	518	552	610	550	90.2
Дээд боловсрол	120	132	145	158	109.0
Мэргэжлийн болон техникийн боловсрол	22	25	31	31	100.0
Дунд боловсрол	340	368	395	337	85.3
Бага боловсрол	29	24	26	20	76.9
Боловсролгүй	7	3	13	4	30.8

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

1.2.4 ТӨРСӨН ЭХ, насны бүлгээр

Үзүүлэлт	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV	<u>2020 I-IV</u> <u>2019 I-IV</u>
Бүгд	518	552	610	550	90.2
20 хүртэлх	36	26	32	26	81.3
20 - 24	147	140	138	130	94.2
25 - 29	136	163	193	148	76.7
30 - 34	108	119	156	144	92.3
35 - 39	72	86	83	82	98.8
40 - 44	19	18	8	20	2.5*
45 - 49					

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

1.2.5 НАС БАРАЛТ

Сумын нэр	Нас баралт								<u>2020 I-IV</u> <u>2019 I-IV</u>
	2017 I-IV		2018 I-IV		2019 I-IV		2020 I-IV		
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	
Бүгд	154	58	170	57	163	57	169	62	103.7
Алтанбулаг	7	3	10	4	11	3	8	3	72.7
Ерөө	14	4	14	4	12	3	9	4	75.0
Зүүнбүрэн	2	1	4	1	5	1	6	1	120.0
Мандал	45	15	57	21	41	16	47	16	114.6
Орхон	3	2	2		2		4	2	2.0*
Сант	4	2			4		1	1	25.0
Цагааннуур	7	1	5	3	5	3	8	4	160.0
Баянгол	5	3	3	1	5		8	3	160.0
Сайхан	12	4	18	7	13	4	9	2	69.2
Орхонтуул	4	3	2		9	3	5	1	55.6
Баруунбүрэн	4	3	3	2	6	5	3	3	50.0
Шаамар	4	2	5	2	5	2	8		160.0
Хүдэр	2		2		3		5	2	166.7
Сүхбаатар	38	14	39	11	38	16	42	19	110.5
Жавхлант	1		2		1		3	1	3.0*
Түшиг				1			2		
Хушаат	2	1			3	1	1		33.3

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.6 НАС БАРАЛТ, насны бүлгээр**


Үзүүлэлт	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV	$\frac{2020 \text{ I-IV}}{2019 \text{ I-IV}}$
Бүгд	154	170	163	169	103.7
эмэгтэй	56	73	85	62	72.9
0 - 1	6	10	3	4	133.3
1 - 5	2	1	2	2	100.0
6 - 18	4		3	2	66.7
19 - 54	45	56	43	41	95.3
54-с дээш	97	103	112	120	107.1

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

1.2.7 НАС БАРАЛТ, зонхилох өвчний ангилалаар

Үзүүлэлт	Нас барсан хүний тоо				$\frac{2020 \text{ I-IV}}{2019 \text{ I-IV}}$
	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV	
Дүн	154	170	163	169	103.7
Зүрх судасны тогтолцооны өвчин	56	73	85	59	69.4
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	19	23	20	18	90.0
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	17	10	9	10	111.1
Амьсгалын тогтолцооны өвчин	5	8	2	10	5.0*
Хавдар	41	41	35	57	162.9
Бусад	16	15	12	15	125.0

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Нас баралт, зонхилох өвчин хувиар

**1.2.8 НЯЛХСЫН ЭНДЭГДЭЛ**

Сумын нэр	0-1 хүртэлх насны хүүхэд			
	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV
Дүн	2	10	3	4
Алтанбулаг				
Ерөө				
Зүүнбүрэн		1		
Мандал		1		1
Орхон				
Сант				
Цагааннуур	1			
Баянгол				
Сайхан		1		
Орхонтуул				
Баруунбүрэн				
Шаамар				
Хүдэр				
Сүхбаатар	1	7	3	3
Жавхлант				
Түшиг				
Хушаат				

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Сумын нэр	1-5 насны хүүхэд			
	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV
Дүн	2	1	2	2
Алтанбулаг				
Ерөө	1			
Зүүнбүрэн				
Мандал	1			
Орхон				
Сант				
Цагааннуур				2
Баянгол				
Сайхан			1	
Орхонтуул				
Баруунбүрэн				
Шаамар				
Хүдэр				
Сүхбаатар		1	1	
Жавхлант				
Түшиг				
Хушаат				

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.9 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГСӨД**

Сумын нэр	Бүх халдварт өвчин				<u>2020 I-IV</u> <u>2019 I-IV</u>
	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV	
ДҮН	214	368	239	367	153.6
Алтанбулаг	10	33	15	39	2.6*
Ерөө	5	11	9	18	2.0*
Зүүнбүрэн	17	5	4	6	150.0
Мандал	25	49	41	66	161.0
Орхон		10			
Сант	1			12	
Цагааннуур	8	17	10	13	130.0
Баянгол	2	28	10	3	30.0
Сайхан	13	31	14	29	2.0*
Орхонтуул	4	4	4	13	3.2*
Баруунбүрэн		2	2	2	100.0
Шаамар	18	9	9	14	155.6
Хүдэр	1	3		20	
Сүхбаатар	102	147	115	111	96.5
Жавхлант	1	4	1	19	19.0*
Түшиг	5	14	3	2	66.7
Хушаат	2	1	2		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Сумын нэр	Бэлгийн замын өвчин				<u>2020 I-IV</u> <u>2019 I-IV</u>
	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV	
ДҮН	109	277	145	316	2.1*
Алтанбулаг	5	28	3	39	13.0*
Ерөө	1	5	3	14	4.6*
Зүүнбүрэн	5	5	3	6	2.0*
Мандал	10	29	24	49	2.0*
Орхон		9			
Сант	1			12	
Цагааннуур	5	16	7	12	171.4
Баянгол		22	3	2	66.7
Сайхан	5	27	5	27	5.4*
Орхонтуул		2	2	9	4.5*
Баруунбүрэн			1	2	2.0*
Шаамар	8	8	8	13	162.5
Хүдэр		2		18	
Сүхбаатар	65	112	82	93	113.4
Жавхлант		1	1	18	18.0*
Түшиг	4	11	2	2	100.0
Хушаат			1		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



Сумын нэр	Гипатит				<u>2020 I-IV</u> <u>2019 I-IV</u>
	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV	
ДҮН	0	2	0	2	-
Алтанбулаг		1			
Ерөө				1	
Зүүнбүрэн					
Мандал					
Орхон					
Сант					
Цагааннуур					
Баянгол					
Сайхан					
Орхонтуул				1	
Баруунбүрэн					
Шаамар					
Хүдэр					
Сүхбаатар					
Жавхлант					
Түшиг					
Хушаат		1			

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Сумын нэр	Сүрьеэ				<u>2020 I-IV</u> <u>2019 I-IV</u>
	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV	
ДҮН	63	66	61	36	59.0
Алтанбулаг	4	3	9		
Ерөө	4	6	6	3	50.0
Зүүнбүрэн			1		
Мандал	15	16	12	15	125.0
Орхон		1			
Сант					
Цагааннуур	3	1	2	1	50.0
Баянгол	2	6	7	1	14.3
Сайхан	5	4	5	2	40.0
Орхонтуул	4	1	2	3	150.0
Баруунбүрэн		2	1		
Шаамар		1	1	1	100.0
Хүдэр		1		1	
Сүхбаатар	23	18	13	8	61.5
Жавхлант		3		1	
Түшиг	1	3	1		
Хушаат	2		1		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ****1.3.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮД, боловсролоор**

үзүүлэлт	2017 I-IV	2018 I-V	2019 I-IV	2020 I-IV	$\frac{2020 \text{ I-IV}}{2019 \text{ I-IV}}$
Бүгд	889	911	760	579	76.2
эмэгтэй	437	479	349	261	74.8
Дээд	285	313	174	140	80.5
Тусгай дунд	58	74	38	33	86.8
Ерөнхий боловсролтой	413	382	385	321	83.4
Мэргэжилтэй ажилчид	127	137	156	82	52.6
Боловсролгүй	6	5	7	3	42.9

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

1.3.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, сумдаар, эхний 4 сарын байдлаар

Сумын нэр	сарын эхний ажилгүйчүүд	тухайн сард хасагдсан		нэмэгдсэн	сарын эцэс
		ажилд зуучлагдсан	идэвхгүйн улмаас хасагдсан		
ДҮН	545	43	86	163	579
Алтанбулаг	14		2		12
Ерөө	64		1		63
Зүүнбүрэн	9		1		8
Мандал	122	3	16	63	166
Орхон	1	1			0
Сант	11	2			9
Цагааннуур	38	10	3	15	40
Баянгол	49	15	3	12	43
Сайхан	20		2		18
Орхонтуул	21				21
Баруунбүрэн					0
Шаамар	28	3	2	8	31
Хүдэр	1		1		0
Сүхбаатар	139	1	55	65	148
Жавхлант	1				1
Түшиг	25	8			17
Хушаат	2				2

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

**1.3.3 ШИНЭ АЖЛЫН БАЙР**

	Бүгд	ХАА, ан агнуур, ОАА, загас агнуур	Уул уурхай, олборлох үйлдвэр	Боловсруулах үйлдвэр	Цахилгаан, дулаан, усан хангамж	Барилга	Худалдаа, гэр ахуйн засвар, үйлчилгээ	Зочид буудал, зоогийн газар	Тээвэр, холбоо	Санхүүгийн үйл ажиллагаа	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа	Боловсрол	Эрүүл мэнд, нийгмийн халамж	Урлаг, үзвэр, үйлчилгээний бусад үйл ажиллагаа
ДҮН	144	36	16	12	1	0	11	0	9	3	1	4	12	36	1	2
Алтанбулаг	13			3										10		
Ерөө	11	2	4				4			1						
Зүүнбүрэн	5			1			1					3				
Мандал	37	26	1	5					2	1	1					1
Орхон	3				1								2			
Сант	5		1						1				2	1		
Цагааннуур	31	1		3			4							23		
Баянгол	14	4	8									1		1		
Сайхан	1												1			
Орхонтуул	3												1		1	1
Баруунбүрэн	0															
Шаамар	11								6				5			
Хүдэр	0															
Сүхбаатар	3		1							1				1		
Жавхлант	0															
Түшиг	7	3	1				2						1			
Хушаат	0															

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

**1.4 НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ****1.4.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН**

Үйлчилгээний төрөл	Хүн	Мөнгөн дүн, сая.төг
Халамжийн тэтгэвэр	2 347	1 679.9
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1 627	532.3
Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	1 492	311.4
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ		
Жирэмсэн эхчүүдэд олгосон мөнгөн тэтгэмж	1 376	123.1
Ахмад дайчин, алдар цолтон ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	70	33.3
Эхийн алдар одонтой эхчүүдэд олгосон тусламж	8 575	1 117.0
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	2 041	118.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	234	28.8
Насны хишиг	4 792	374.6
Цалинтай ээж хөтөлбөр	5 495	996.5
Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөр	204	83.6
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	5 708	266.9
Нийт	33 961	5 666.1

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

1.4.2 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОРЛОГО, АВЛАГА, сумаар, сая.төг

Сумдын нэр	НДШ-н орлого			НДШ-н авлага		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Аж ахуйн нэгж	Төсөв	Бүгд
ДҮН	14 290.6	12 655.7	88.6	9 937.9	58.5	9 996.4
Алтанбулаг	212.4	243.5	114.6	32.6	3.3	35.9
Ерөө	1 779.2	1 138.9	64.0	55.4	24.5	79.9
Зүүнбүрэн	148.0	135.1	91.3	19.5	0.3	19.8
